

Увс аймаг дахь Төрийн аудитын газар



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Увс аймгийн "Улаангом тохижилт үйлчилгээ" ОНТҮГ-ын 2021 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/1/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn
Увс аймгийн Улаангом сум
2022 он

Цахим хуудас: uvs@audit.gov.mn

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317 Цахим хаяг:
BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799 Цахим хаяг:
Bat-Amgalanm@audit.gov.mn

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн "Увс Финанс аудит"
ХХК аудитор: Я.Тунгалаг

Утас: 99459698 Цахим хаяг:
anuganzorig85@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Товчилсон үгийн жагсаалт.....	2
2.Аудитын санал дүгнэлт.....	3-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6-7
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9-10
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	12-13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.1 Байгууллагын үйл ажилагаа.....	14
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	15-17
4. Аудитын тайлан.....	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Дотоод хяналт	18
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	19
4.4 Материаллаг байдал.....	19
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
5.1 Шилэн дансны мэдээлэл	19-20
6. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
7. Аудитын илрүүлэлт	20
7.1 Залруулсан алдаа.....	20-21
7.2 Төлбөрийн акт.....	21
7.3 Албан шаардлага	21-22
8. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400. Увс аймаг. Улаангом сум.
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17. Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

АЙМГИЙН "УЛААНГОМ
ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ"
ОНТҮГ-ЫН ДАРГА
Э.БАТБАЯР ТАНАА

2022.03.15 № УБА - 2022/01/НА - СТА - ОНА
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Увс аймгийн "Улаангом тохижилт үйлчилгээ" ОНТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Увс аймгийн "Улаангом тохижилт үйлчилгээ" ОНТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Увс аймгийн "Улаангом тохижилт үйлчилгээ" ОНТҮГ нь тээвэр шатахууны зардлаас 36,461.4 мянган төгрөгийн 15163 литр шатах тослох материалын замын хуудасны тооцоог бодохгүйгээр хяналтгүйгээр зарцуулсан, байгууллагын даргын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/26 дугаар тушаалаар ажилтнуудад нормын хувцас олгох гэж шийдвэр гарган 7 ажилтанд тус бүр 150.0 мянга, нийт 1,050.0 мянган төгрөгийг харилцах данс руу шилжүүлэн өгч орон нутгийн өмч хөрөнгөнд хохирол учруулсан зэрэг зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь заалтад "Тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", Зам тээврийн хөгжлийн сайдын "Жишиг норм батлах тухай" 2019 оны 390 дугаар тушаал, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 5.5 дахь заалтад "Батлагдсан төсвийг зориулалтын

0200200579

дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулалт олж авах, гүйлгээг бүртгэхгүй байх”, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалтад “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт “Үнэн зөв байх” заалттай нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М. БАТСУУРЬ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	37,766,568.60	114,550,715.86
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	38,500.00	60,544,462.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	38,500.00	60,544,462.00
3121	Төгрөг	38,500.00	60,544,462.00
31213	Арилжааны банк дахь харилцах	38,500.00	60,544,462.00
33	АВЛАГА	387,108.60	6,241,293.86
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	9,185.26
335	Бусад авлага	387,108.60	6,232,108.60
3352	Хувь хүмүүсээс авах авлага	387,108.60	6,232,108.60
35	БАРАА МАТЕРИАЛ	37,340,960.00	47,764,960.00
354	Хангамжийн материал	37,340,960.00	47,764,960.00
35420	Аж ахуйн материал	5,300,000.00	5,405,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,490,000.00	1,490,000.00
35470	Бусад хангамжийн материал	30,550,960.00	40,869,960.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	18,858,174,978.01	3,589,057,362.17
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	18,858,174,978.01	3,589,057,362.17
392	Биет хөрөнгө	18,331,514,978.01	3,062,463,362.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	23,978,697,695.54	2,756,854,990.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	(7,687,703,879.84)	(851,771,338.73)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	795,098,659.00	997,608,659.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(519,497,468.93)	(571,849,075.82)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	36,918,100.00	36,918,100.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(24,682,717.14)	(30,302,283.78)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,201,514.42	7,567,314.42
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,361,397.76)	(4,065,371.15)

39214	Бусад үндсэн хөрөнгө	2,455,452,332.86	972,173,951.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(735,033,939.14)	(279,097,662.62)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	28,426,079.00	28,426,079.00
393	Биет бус хөрөнгө	526,660,000.00	526,594,000.00
39301	Программ хангамж	1,100,000.00	1,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(440,000.00)	(506,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	526,000,000.00	526,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	18,895,941,546.61	3,703,608,078.03
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	43,250,300.00	44,911,554.95
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	43,250,300.00	44,911,554.95
413	Өглөг	43,250,300.00	44,911,554.95
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	50,300.00	1,701,284.00
4136	Бусад өглөг	43,200,000.00	43,210,270.95
41361	Байгууллагад төлөх өглөг	43,200,000.00	43,160,270.95
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	50,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	18,852,691,246.61	3,658,696,523.08
51	Засгийн газрын хувь оролцоо	18,852,691,246.61	3,658,696,523.08
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	10,558,951,159.56	10,558,951,159.56
51101	Өмч: - төрийн	10,558,951,159.56	10,558,951,159.56
512	Хуримтлагдсан үр дүн	4,568,709,017.09	(7,045,877,949.72)
51210	Өмнөх үеийн үр дүн	4,568,709,017.09	(5,379,841,321.02)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(1,666,036,628.70)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,725,031,069.96	145,623,313.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	18,895,941,546.61	3,703,608,078.03



2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,671,501,973.56	1,567,812,632.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,079,082,173.56	932,560,832.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,079,082,173.56	932,560,832.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,078,736,658.80	932,560,832.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	5,845,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	102,209,183.00	247,814,890.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,976,527,475.80	678,900,942.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	551,462,500.00	594,294,500.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	40,957,300.00	40,957,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	551,462,500.00	594,294,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	551,462,500.00	594,294,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,527,368,071.00	2,998,426,277.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,527,368,071.00	2,998,426,277.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,517,194,071.00	2,987,410,877.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	297,505,652.00	316,758,668.00
210101	Үндсэн цалин	297,505,652.00	316,758,668.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,766,856.63	46,949,441.74
210201	Тэтгэврийн даатгал	42,766,856.63	46,949,441.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,776,007.00	98,940,932.00
210301	Гэрэл, цахилгаан	72,477,743.00	84,486,551.00
210302	Түлш, халаалт	13,694,375.00	13,826,000.00
210303	Цэвэр, бохир ус	603,889.00	628,381.00
2104	Хангамж, бараа материалын зардал	86,171,388.00	112,870,124.95
210401	Бичиг хэрэг	2,384,598.00	2,049,500.00
210402	Тээвэр, шатахуун	78,980,230.00	99,369,204.95
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,244,560.00	1,426,670.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,562,000.00	4,168,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	5,856,150.00
2105	Нормативт зардал	6,624,000.00	5,100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,624,000.00	5,100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	70,018,643.00	36,913,800.00
210604	Урсгал засвар	70,018,643.00	36,913,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,711,843.00	13,280,582.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,218,420.00	7,596,420.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	1,620,000.00

210201	Тэтгэврийн даатгал	38,410,972.00	38,333,648.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,545,329.00	94,493,952.00
210301	Гэрэл, цахилгаан	49,756,092.00	81,333,771.00
210302	Түлш, халаалт	6,301,900.00	12,531,800.00
210303	Цэвэр, бохир ус	487,337.00	628,381.00
2104	Хангамж, бараа материалын зардал	60,445,086.00	115,563,553.00
210401	Бичиг хэрэг	1,395,250.00	1,266,200.00
210402	Тээвэр, шатахуун	54,534,130.00	103,267,933.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	953,706.00	1,499,670.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,562,000.00	3,750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	5,779,750.00
2105	Нормативт зардал	4,000,000.00	5,100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,000,000.00	5,100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	64,912,863.00	37,871,900.00
210604	Урсгал засвар	58,781,363.00	37,871,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,548,650.00	13,780,582.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,460,280.00	7,805,420.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	1,620,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	707,670.00	611,325.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	353,700.00	518,536.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	286,000.00	385,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,165,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	00.00	2,807,301.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	105,815,807.97	127,023,730.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	105,815,807.97	127,023,730.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,724,000.00	18,737,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,724,000.00	18,737,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,924,000.00	11,823,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	6,914,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-40,064,317.21	107,581,762.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	47,075,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	47,075,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	47,075,800.00
223001	Бусад хөрөнгө	00.00	47,075,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-47,075,800.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-40,064,317.21	60,505,962.00

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Увс аймгийн "Улаангом тохижилт үйлчилгээ" ОНТҮГ нь Улаангом хотын оршин суугчдын ажиллаж амьдрах ая тохитой орчинг бүрдүүлэхийн төлөө үйл ажиллагаагаа тогтвортой, найдвартай, хүртээмжтэй, тасралтгүй байдлаар хангахад зорилтоо тодорхойлсон байна.

Тайлант онд дараах дэд зорилтуудыг дэвшүүлжээ.

- Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлэг, түүний засвар үйлчилгээ
- Хотын ногоон байгууламж нэмэгдүүлэх, арчлан тордох, нөхөн сэргээх
- Нийтийн байр орон сууц, гэрээт ААН, байгууллага, гэр хорооллын хог хаягдлыг ачиж тээвэрлэх, булж дарах
- Улаангом хотын "0" гортигийн нийтийн эзэмшлийн зам, талбай, ногоон байгууламж, түүхийн дурсгалт газрын цэвэрлэгээ
- Золбин нохой, муур устгах
- Хаяг реклам, зар сурталчилгааны самбар байршуулах зэрэг бусад ажил үйлчилгээ явуулна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

2006 онд Хот тохижилт, орон сууцны үйлчилгээний газар нэртэйгээр 23 хүний бүтэц, орон тоотойгоор байгуулагдсан байна. Увс аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны А/25 дугаар тогтоолоор "Улаангом тохижилт үйлчилгээ" Орон нутгийн төсөвт үйлчилгээний газар болгон өөрчилж 34 бүтэц орон тоотойгоор байгуулсан байна.

Увс аймгийн Засаг даргын захирамжаар 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн Б/04 дүгээр захирамжаар Компанийн удирдлагыг томилсон байна. ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 2020 оны 5 дугаар сарын 18 ний өдрийн А/278 дугаар захирамжаар Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн дарга, бусад хэлтсүүдийн мэргэжилтнүүдээс бүрдсэн нийт 5 гишүүнтэйгээр томилсон байна. ТУЗ нь 2021 онд 7 удаа хуралдаж 20 асуудал хэлэлцэж, 19 тогтоол, 1 албан бичиг гаргасан байна.

ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 3.7-д "Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" гэсэн заалтай нийцэж байна. 2021 онд ТУЗ-ийн цалин урамшууллын зардалд 8,839.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 7,373.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 04 ний өдрийн 01 дүгээр тогтоолоор Увс аймгийн "Улаангом тохижилт үйлчилгээ" ОНТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг, 2021 оны 1 дүгээр сарын

Увс аймгийн “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оны үлдэгдлээс үндсэн хөрөнгө 15,192,333.5 мянган төгрөг буюу 81 хувиар, мөнгөн хөрөнгө 100 хувь, бараа материалын данс 22 хувиар өссөн өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн дансны өсөлт нь харилцах данс дахь 60,544.5 мянган төгрөгийн үлдэгдлээс хамааралтайгаар өссөн нь байна. Энэ нь төсөвт тусгагдсан хог ачих зориулалт бүхий том оврын автомашин худалдан авах байсан боловч цаг үеийн байдал болон хил хаагдсантай холбоотойгоор худалдан авалт хийгдээгүй байна.

Бараа материалын үлдэгдэл 22 хувь буюу 10,424.0 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй ба байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулахтай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,703,608.1 мянган төгрөг болж 15,535,155.5 мянган төгрөгөөр буурсан нь аймгийн Орон нутгийн өмчийн албаны шийдвэрээр балансаас баланст хөрөнгө шилжүүлсэнтэй холбоотой гарсан өөрчлөлт байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,658,696.5 мянган төгрөг болж 15,193,994.7 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө болон тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 4,103,689.3 мянган төгрөгөөр буюу 72 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь өмнөх онуудад тухай байгууллагад томоохон үнийн дүнтэй нийтийн эзэмшлийн зам талбайн хөрөнгө оруулалтын ажлуудыг бүртгэж байсантай холбоотой байна. Харин тайлант онд 678,900.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй бүртгэсэн байна.

Тайлант онд нийт зардал нь өмнөх оны зардлаас 471,058.2 мянган төгрөгөөр буюу 16 хувиар буурсан байна. Энэ нь үндсэн хөрөнгийг бусад байгууллагад шилжүүлсэнтэй холбоотойгоор элэгдлийн зардлын 480,530.6 мянган төгрөгийн буурсан үзүүлэлт нөлөөлсөн байна.

Мөн эрх шилжиж ирсэн ногоон байгууламжийн төсөл арга хэмжээний ажил хийж гүйцэтгэсэнтэй холбоотойгоор хангамжийн материалын зардал өмнөх оноос 26,698.7 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Санхүүгийн байдал, орлого, үр дүн, өмчийн өөрчлөлтийн тайланд нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдсэн болно.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөл, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Увс аймгийн “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, ТУЗ-өөр батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 04 ний өдрийн 02 дугаар тогтоолоор Увс аймгийн “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 941.972.7 мянган төгрөгийн орлого, 941.972.7 мянган төгрөг зарлагатай төсвийн саналыг ТУЗ-д оруулсныг үйлчилгээний орлогоос тодорхой хэмжээгээр санхүүжих эх үүсвэрийг бий болгох чиглэл өгч төсвийг нь 303,935.5 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

ТУЗ-аар үйл ажиллагаанаас 2021 онд нийт 638,037.8 мянган төгрөгийн орлого, 10,096,699.8 мянган төгрөгийн зардал, 9,458,661.9 мянган төгрөгийн алдагдалтай ажиллагааг төлөвлөж батлуулсан байна.

Төлөвлөлтөд орон нутгийн төсвөөс, 546,462.5 мянга, орон нутгийн хөгжлийн сангаас 40,957.3 мянга, үндсэн үйл ажиллагаанаас 50,618.0 мянга, нийт 638,038.2 мянган төгрөгийг санхүүжилт авч олж үйл ажиллагаагаа явуулахаар тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 594,294.5 мянга, Орон нутгийн хөгжлийн сангаас 40,957.3 мянга, эрх шилжиж ирсэн ногоон байгууламж, 3-р багийн хог хаягдлын менежментийн тендерийн нийт 200,000.0 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагаанаас 24,078.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, ИТХ-ын тогтоолоор 8,736.0 мянга, Байгаль орчныг хамгаалах сангаас 15,000.0 мянган төгрөгийн дэмжлэгийг авч, урсгал үйл ажиллагаанд нийт 822,560.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нийт орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 245,028.8 мянган төгрөгөөр давуулан биелэгдсэн нь тендерийн орлого, бусад санхүүгийн дэмжлэгээс хамааралтай байна.

Үйл ажиллагааны нийт 1,567,812.6 мянган төгрөгийн орлого, 3,233,849.3 мянган төгрөг зардалд зарцуулж, тайлант онд 1,666,036.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нөлөөлсөн байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад Увс аймгийн “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-ын санхүүгийн тайлагналтай холбоотой залруулсан алдаа зөрчил, төлбөрийн акт, албан шаардлагыг тусгасан болно.

Аудитыг “Увс Финанс Аудит” ХХК-ийн аудитор Я.Тунгалаг гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Я.Нарантуяа, чанарын хяналтыг Увс аймгийн Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар хэрэгжүүлсэн.

Увс аймгийн “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Увс Финанс Аудит” ХХК-д 2022 оны 02 дүгээр сарын 15-ны өдрийн 12 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна .

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба өмнөх оны санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан дотоод аудит хяналт шалгалт хийсэн байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,295,929.9 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 6,479.6 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1,567,812.6 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 7,839.0 мянган төгрөгөөс гүйцэтгэлийн материаллаг байдлын хувийг 80 хувиар тооцож 6,271.3 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

Гүйцэтгэлийн үе шатанд 271.882,9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулсан гүйлгээ хийгдсэн тул тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд

зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Увс аймгийн "Улаангом тохижилт үйлчилгээ" ОНТУГ-ын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгах аар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 167 мэдээллээс хугацаандаа оруулсан 151, хугацаа хоцроож 16 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж гараагүй байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үндсэн үйл ажиллагааны орлогыг тулган баталгаажуулах шаардлагатай.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 309,516.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 272,005.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,050.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 36,461.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага өглөө.

8.1 Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад "Үнэн зөв байх", 14 дүгээр зүйл 14.4 дэх хэсэгт "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2 дахь заалтад "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.6 дахь заалтад "бүх зардал" гэж заасныг тус тус зөрчсөн дараах алдаа зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Гэрээний дагуу хог ачих, самбарын түрээсийн үйлчилгээ үзүүлсэн харилцагч нараас авах 5,845.0 мянган төгрөгийн төлбөрийг санхүүгийн тайланд авлагаар тайлагнаагүй байна.
- НДШ-ийн 9.2 мянган төгрөгийн илүү төлөлтийг санхүүгийн тайланд авлагаар тайлагнаагүй байна.
-

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд авлагаар тусгаж залруулав.

- Ажилтанд өгсөн 113.3 мянган төгрөгийн тэтгэмжийн зардлыг дутуу илэрхийлж санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд зардлыг тусгаж залруулав.

- Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 266,037.9 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тайлагнаагүй байна.

Шийдвэрлэсэн: Хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаж залруулав.

8.2 Төлбөрийн акт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 5.5 дахь заалт "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалтад "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэж заасныг тус тус зөрчин Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын даргын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/26 тоот тушаалаар ажилтнуудад нормын хувцас олгох шийдвэр гаргаж 7 ажилтанд тус бүрт 150.0 мянга, нийт 1050.0 мянган төгрөгийг ажилтнуудын харилцах данс руу шилжүүлэн өгч орон нутгийн өмч хөрөнгөнд хохирол учруулсан байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоолоо.

8.3 Зөрчлийн албан шаардлага

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь заалтад "Тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна",



13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар “Жишиг норм батлах тухай” тушаалыг хэрэгжүүлэхгүйгээр тээвэр шатахууны зардлаас 36,461.4 мянган төгрөгийн 15163 литр шатах тослох материалыг зарцуулахдаа замын хуудас хөтлөөгүй, зарцуулалтын тооцоо бодохгүй хяналтгүйгээр зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага өглөө.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	/мян.төг/									
		Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Увс аймгийн “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ	6	309,516.9	4	272,005.5	1	1,050.0	1	36,461.4	0	0


Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН::

УВС ФИНАНС АУДИТ ХХК-ийн АУДИТОР

/Я.ТУНГАЛАГ/

2021 оны 3-р сарын 15-ны өдөр